

АНУ-ИРАНЫ ЗӨРЧИЛ ДЭЛХИЙН ГАЗРЫН ТОСНЫ ЗАХ ЗЭЭЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Л.Бямбахант*

***Abstract:** This article looks at how US-Iranian relations which directly and indirectly affect global oil market. This is because in September 2019, the conflict between the two countries escalated and came to the brink of war. Although Washington and Tehran have managed to avoid the threat of war, there is no guarantee that this will not happen again. On the other hand, with the new administration formed as a result of the 2020 US presidential election, Washington's policy toward Iran is expected to change, and its eagerness to sit down with Tehran at the negotiating table is expected to bring positive outcomes which would stabilize oil prices.*

The first part of the article provides an overview of US-Iranian relations, focusing on the policies of US presidents on Iran. The second part of the article discusses Iran's position and influence in the world oil market, as well as the changes that could take place in the world oil market as a result of the US-Iran nuclear talks that began in April this year. The concluding part of the article presents the researcher's position on the impact of changes and implications on the world oil market which might appear related to the US-Iran relations on Mongolia.

***Keywords:** US-Iranian relations, Oil policy*

Оршил

АНУ-Ираны харилцаа нь Ойрхи Дорнодын нөхцөл байдал, цаашлаад дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ ханшийг тодорхойлоход чухал үүрэгтэй билээ. 2014 онд Өрнөдийн орнууд Ирантай цөмийн тохиролцоонд хүрч, тус улс дэлхийн зах зээлд газрын тосоо нийлүүлж эхэлснээр нефтийн үнэ буурсан байдаг. Одоогоор нефтийн бүтээгдэхүүний хувьд экспортоос бүрэн хамааралтай байгаа манай улсын хувьд дэлхийн газрын тосны зах зээлийн хөдөлгөөн, цаашдын хандлагыг ажиглаж байх нь стратегийн чухал ач холбогдолтой асуудал юм.

Энэхүү өгүүлэлд АНУ-Ираны харилцаа дэлхийн газрын тосны зах зээлд хэрхэн нөлөөлдөг болохыг авч үзлээ. Учир нь 2019 оны 9 дүгээр сард хоёр улсын хоорондын зөрчил хурцдан, дайны ирмэгт тулж ирсэн юм. Хэдийгээр Вашингтон, Тегеран дайны аюулаас сэргийлж чадсан боловч дахин ийм байдал үүсэхгүй гэх нөхцөл үгүй билээ. Нөгөөтэйгүүр, АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуулийн үр дүнд шинэ засаг захиргаа бүрэлдсэнтэй холбогдуулан Вашингтоны Ираны

* ШУА-ын ОУХХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, судлаач

талаар баримтлах бодлогод өөрчлөлт гарч, Тегерантай яриа хэлэлцээний ширээний ард суух бодлого баримтлах болсноор дэлхийн газрын тосны зах зээлд тодорхой өөрчлөлт авчрах төлөвтэй байна.

Өгүүлэлийн эхний хэсэгт АНУ-Ираны харилцааг тоймлон авч үзэх бөгөөд ингэхдээ АНУ-ын үе, үеийн ерөнхийлөгчийн Ираны талаар баримталж байсан бодлогод анхаарал хандуулж, дүгнэлт өгсөн болно. Хоёрдугаар хэсэгт, Ираны дэлхийн газрын тосны зах зээлд эзлэх байр суурь, үзүүлэх нөлөөний талаар дурдахын зэрэгцээ энэ оны 4 дүгээр сараас эхэлсэн АНУ-Ираны хооронд явагдаж цөмийн гэрээтэй холбоотой яриа хэлэлцээний үр дүнд дэлхийн газрын тосны зах зээлд ямар өөрчлөлт гарч болохыг авч үзэв. Өгүүлэлийн дүгнэлтийн хэсэгт, АНУ-Ираны харилцаатай холбоотой дэлхийн газрын тосны зах зээлд гарах өөрчлөлт, нөлөө нь Монгол Улсад хэрхэн нөлөөлөх тухайд судлаачийн байр суурийг илэрхийлсэн болно.

Нэг. АНУ-Ираны харилцаа: Өнгөрсөн, одоо

1979 оны 2 дугаар сарын 11-ний өдөр “Исламын хувьсгал” гарахаас өмнө Иран нь АНУ-ын Ойрхи Дорнод дахь чухал түнш байсан билээ. Хувьсгалын дараагаас эхлэн АНУ-Ираны харилцаа ихэнхдээ дайсагнасан байдалтай байсаар ирсэн. Иран нь Ойрхи Дорнод дахь зэвсэгт бүлэглэлүүдийг дэмжсээр ирсэн нь АНУ-ын ашиг сонирхол, холбоотнуудад ноцтой аюул учруулж байна хэмээн АНУ-ын албаны хүмүүс үздэг. Ерөнхийлөгч Ж.Картерын засаг захиргааны үед Ираны шинэ дэглэмтэй харилцаа тогтоохыг оролдож байсан боловч 1979 оны 11 дүгээр 4-ний өдөр Хомейнийг дэмждэг “Имамыг дэмжигч оюутнууд” гэх бүлэглэл Тегеран хот дахь АНУ-ын Элчин сайдын яамыг барьцаанд авснаар энэ оролдлого дуусгавар болсон. Тус бүлэглэл америкийн 66 дипломатыг 444 өдрийн хугацаанд барьцаалсны эцэст “Алжирын тунхаглал”²-ын дагуу 1981 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр сулласан билээ. Ерөнхийлөгч Р.Рейган тангараг өргөснөөс хойш хэдхэн минутын дараа америкийн дипломат ажилтнуудыг суллах үйл ажиллагаа явагдаж дуусчээ. Үүний өмнө АНУ нь барьцаанд байсан хүмүүсийг цэргийн хүчээр суллахыг оролдсон оролдлого нь бүтэлгүйтсэн бөгөөд энэхүү цэргийн ажиллагаанаас хоёр долоо хоногийн өмнө буюу 1980 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр АНУ нь Ирантай дипломат харилцаагаа тасалсан байна.

Бейрутад байрлах тэнгисийн цэргийн баазыг 1983 оны 10 дугаар сард бөмбөгдсний хариуд Р.Рейганы засаг захиргааны үед буюу 1984 оны 1 дүгээр сард “терроризмын дэмжигч улс” хэмээн зарласан. Иран-Иракийн хооронд 1980-1988 онд болсон дайны явцад Р.Рейганы засаг захиргаа Иракийг мөн “терроризмын дэмжигч улс” хэмээн зарласан байдаг. 1987-1988 оны хооронд АНУ-ын тэнгисийн

² Алжирын тунхаглал нь Иранд Америкийн дипломат ажилтнууд барьцаалагдсан хямралыг шийдвэрлэх зорилгоор Алжирын засгийн газрын зуучлалтайгаар АНУ болон Ираны хоорондын байгуулсан цогц гэрээ бөгөөд 1981 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Алжирт хоёр тал гэрээнд гарын үсэг зурсан.

цэргийн хүчин Ираны тэнгисийн хүчинтэй хэд хэдэн удаагийн тулаан хийжээ. 1988 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Иран улс АНУ-ын тэнгисийн хүчинтэй мөргөлдсний улмаас хөлөг онгоцуудынхаа 1/4-ээ алдаж ихээхэн хохирол амсчээ. Иран-Иракийн дайнд Иракийг дэмжсэн атлаа Иран Ливанд барьцаанд байсан америкийн иргэдийг тусласны хариуд Иранд зэвсэг (TOW танк эсэргүүцэгч, I-Hawk агаарын хамгаалалтын зэвсэг зэрэг) нийлүүлэх зэргээр өөр хоорондоо зөрчилтэй бодлого явуулж байв. 1988 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Персийн булан дахь АНУ-ын цэргийн хүчин Ираны иргэний агаарын тээврийн 655 дугаартай нисэх онгоцыг андуурч устгаснаар онгоцонд зорчиж явсан 290 хүн амь насаа алдсан нь Ираныг 1988 оны 8 дугаар сард Ирактай гал зогсоох гэрээ байгуулахад ихээхэн нөлөөлсөн.

Ерөнхийлөгч Ж.Буш 1989 оны 1 дүгээр сард тангараг өргөхдөө Ираны талаар “сайн санаа сайн санааг төрүүлдэг” хэмээн хэлсэн. Энэ нь Ливанд Хезболлад барьцаалагдсан хүмүүсийг суллахад тусласан тохиолдолд АНУ-Ираны харилцаа сайжрах боломжтой гэдгийг илэрхийлсэн хэрэг байлаа. Ираны илэрхий туслалцаатайгаар 1991 оны 12 дугаар сарын сүүлээр барьцаанд байсан АНУ-ын үлдсэн хүмүүсийг суллаж чадсан. Гэвч Ерөнхийлөгч Ж.Бушийн засаг захиргааны хүлээлтийн дагуу хоёр талын харилцаа сайжирсангүй. Учир нь Араб-Израилийн энхийн гэрээг эсэргүүцсэн байр суурьтай байсан Иран нь зэвсэгт бүлэглэлүүдийг дэмжиж байсантай холбоотой.

Б.Клинтоны засаг захиргаа Иран, Иракийг хамтад нь тогтоон барих “давхар хязгаарлах” стратеги буюу аль нэгийг нь дэмжих гэхээсээ илүү хоёулангийнх нь хүчийг адилхан сулруулахыг оролдож байв. Израйль-Палестины энхийн үйл явцын ач холбогдлыг сулруулах зорилго бүхий террорист бүлэглэлүүдэд Иран дэмжлэг үзүүлсний хариуд 1995-1996 онд Б.Клинтоны засаг захиргаа Ирантай худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа тогтоохыг хориглож, тус улсын эрчим хүчний салбарт хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулалтад хориг тавихаар болсон. 1997 онд аядуу үзэлтэй Мохаммед Хатеми ерөнхийлөгчөөр сонгогдсон явдал нь АНУ-ыг Ирантай шууд яриа хэлэлцээ хийх явдлыг түргэтгэсэн боловч М.Хатеми саналыг нь хүлээн аваагүй юм. 1998 онд тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт харилцааг хэвийн болгох зорилготой “замын зураглал” гаргахад харилцан итгэлцэл чухал гэдгийг уриалсан. Мөн АНУ нь Ираны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байснаа М.Олбрайт 2000 онд хүлээн зөвшөөрчээ.

2002 оны 1 дүгээр сард Конгрессын нэгдсэн хуралдаанд тавьсан илтгэлдээ Ерөнхийлөгч Бага Ж.Буш Иран, Ирак, Умард Солонгос улсыг “муу ёрын тэнхлэг”-ийн улсууд хэмээн нэрлэсэн боловч Ж.Бушийн засаг захиргаа Талибаны дараах Афганистан болон Саддамын дараах нөхцөл байдлыг тогтворжуулах үйл ажиллагаандаа Ираны дипломат дэмжлэгийг авахыг зорьж байв.

Ерөнхийлөгч Б.Обама цөмийн хөтөлбөрийг нь хязгаарлахын тулд Ираныг ятгаж, хэдэн арван жил үргэлжилсэн дайсагналынхаа эцэст АНУ-Ираны харилцааг дахин сэргээх боломжтой хэмээн үзэж байв. Энэхүү бодлого нь Ерөнхийлөгч

Б.Обамагийн Новрузын баяр (Персийн шинэ жил)-ыг тохиолдуулан Ираны ард иргэдэд хандан 2009 оны 3 дугаар 21-ний өдөр хэлсэн үгэнд тусгалаа олсон бөгөөд тэрээр “АНУ нь бидний өмнө байгаа бүрэн хэмжээний асуудлыг шийдвэрлэх, АНУ, Иран, олон улсын хамтын нийгэмлэгийн дунд бүтээлч харилцаа тогтоохын төлөө байна” хэмээн мэдэгдсэн билээ. Б.Обама Ираныг “Исламын Бүгд найрамдах Иран улс” хэмээн нэрлэсэн явдал нь АНУ-ын олон жилийн туршид Иранд исламын дэглэм тогтсон гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж ирсэн бодлогыг өөрчилсөн хэрэг болсон юм.

Б.Обамагийн засаг захиргаа олон улсын хурал, чуулганд оролцох үеэрээ АНУ-ын дипломатуудыг Ираны төлөөлөгчидтэй уулзахад саад болсон хязгаарлалтуудыг сулруулсан. 2009 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Каирт “Исламын ертөнц”-д хандан үг хэлэхдээ, Ерөнхийлөгч Б.Обама АНУ нь Ираны Ерөнхий сайд Мохаммед Моссадыкийг түлхэн унагахад оролцсон гэдгийг хүлээн зөвшөөрч, Иран нь энхийн зорилгоор цөмийн эрчим хүчтэй болох эрхтэй хэмээн мэдэгдсэн.³ Мөн Ерөнхийлөгч Б.Обама Ирантай харилцах харилцаанд дэмжлэг үзүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн захидлыг Ираны Дээд удирдагч Хаменейд илгээсэн билээ.

2009 онд Иран нь дотооддоо өрнөсөн Ногоон хөдөлгөөний бослого тэмцлийг нухчин дарж, цөмийн хөтөлбөрөө хязгаарлах буулт хийхээс татгалзсан учраас Б.Обамагийн засаг захиргаа “хоёр суваг”-ийн стратеги буюу эдийн засгийн хатуу дарамт шахалт үзүүлэхийн зэрэгцээ яриа хэлэлцээ хийсэн тохиолдолд хоригийг сулруулах боломжтойг ойлгуулах бодлогыг хэрэгжүүлсэн. 2010-2013 оны хооронд Ираны эсрэг авсан хориг арга хэмжээнүүд нь олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг авч, Иранд эдийн засгийн хүндрэлийг бий болгосон. Гэхдээ Ираны иргэд засгийн газрын хяналтыг тойрч, интернет хэрэглэх талаар дүрэм журмуудыг батлах зэргээр иранчуудад ээлтэй бодлого явуулсан.

2013 оны эхээр Оман улсад Америкийн засаг захиргааныхан Ираны албаныхантай шууд уулзаж, цөмийн асуудлаар иж бүрэн тохиролцоонд хүрэх сонирхолтой эсэхийг нь тандсан. Үүний зэрэгцээ, Б.Обамагийн засаг захиргаа цэргийн хүчээр асуудлыг шийдэх сонголт байсаар байгааг анхааруулж байв. 2013 оны 6 дугаар сард Ираны Ерөнхийлөгчөөр Роухани сонгогдсон явдал нь АНУ дипломат харилцаанд илүү ач холбогдол өгөхөд хүргэсэн юм. Ерөнхийлөгч Б.Обама 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд үг хэлэхдээ Ираны Ерөнхийлөгч Роуханитай захидал солилцсон гэдгээ хүлээн зөвшөөрч, АНУ нь цөмийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийн төлөө байгаагаа илэрхийлэн, АНУ нь Ираны дэглэмийг солихыг оролдохгүй хэмээн мэдэгдсэн билээ. Хоёр улсын ерөнхийлөгч 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр утсаар ярьсан явдал Ираны хувьсгалаас хойш анх удаа АНУ, Иран нь ерөнхийлөгчийн түвшинд харилцсан хэрэг болов.

Нөгөөтэйгүүр, АНУ нь Ирантай харилцаагаа сайжруулахаас өөр аргагүй

³ The New York Times “Text: Obama’s Speech in Cairo” (June 4, 2009)
<https://www.nytimes.com/2009/06/04/us/politics/04obama.text.html> (accessed May 1, 2021)

нөхцөл үүссэн нь Крымийн асуудал байв. ОХУ нь 2014 онд Крымийг өөртөө нэгтгэж авсан нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчмуудыг ноцтой зөрчсөн хэрэг явдал болсон төдийгүй энэ хэрэг явдал Оросыг “шийтгэх”-эд Иран зайлшгүй ашиглах шаардлага үүсгэсэн юм. Өөрөөр хэлбэл, ОХУ-ын экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн болох газрын тосны үнийг дэлхийн зах зээл дээр унагах, улмаар хоригийн тусламжтайгаар Оросыг сөхрүүлэх бодлого баримтлахыг зорьж байв. Үүний тулд Ирантай харилцаагаа сайжруулах, улмаар тус улсын үйлдвэрлэж газрын тосыг дэлхийн зах зээл руу нийлүүлж, газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үнэд нөлөөлөхийг Б.Обамагийн засаг захиргаа төлөвлөж байлаа. Мэдээжийн хэрэг, Оросын “асуудал”-ыг шийдвэрлэхийн тулд Ираныг цөмийн зэвсэгтэй болгож, Ойрхи Дорнодын өнөөгийн хүчний тэнцвэрийг өөрчлөх сонирхол АНУ-д байхгүй байсан учраас Ирантай “цөмийн тохиролцоо” хийхийг яаравчилж байсан нь амжилтанд хүрсэн юм.

Иран болон Пи 5+1 (НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн+Герман)+Европын холбоо хооронд Ираны цөмийн асуудлаарх суурь гэрээг 2015 оны 4 дүгээр сард баталж, 7 дугаар сард Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөө (ҮАХИБТ)-г баталсан байна. Энэ тохиролцооны дагуу Иран цөмийн хөтөлбөрөө⁴ 10 жилийн хугацаанд зогсоож, Өрнөдийн орнууд тавьсан хориггоо зөөлрүүлж, Иран бусад улсын адил “энгийн улс” болж хөгжих боломж олгосон юм.

ҮАХИБТ-д заасны дагуу энэхүү гэрээг олон улсын эрх зүйн баримт бичиг болгохоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд өргөн барьсан бөгөөд Аюулгүйн зөвлөл НҮБ-ын АЗ-ийн 2231 тоот тогтоолыг санал нэгтгэйгээр (15-0 харьцаатай) 2015 оны 7 дугаар сарын 14-ны өдөр баталжээ. Уг тогтоолын дагуу Иранд тавьсан АЗ-ийн сүүлийн 7 хориг арга хэмжээг цуцлах боловч зэвсгийн худалдаа, цөмийн технологид тавьсан хориггоо хэвээр үлдээсэн юм. Мөн энэ тогтоол нь АНУ, Европын Холбооноос дангаар тавьсан хоригуудад нөлөөлөхгүй. НҮБ-ын АЗ-ийн тогтоол батлагдсан өдөр ЕХ-ны Гадаад бодлогын зөвлөлийн Брюссельд болсон хуралдаанаар энэхүү ҮАХИБТ-г ЕХ албан ёсоор батлав. Энэ дагуу ЕХ Иранаас газрын тос худалдан авахгүй байх хориггоо цуцлах боловч хүний эрхтэй холбоотой болон баллистик пуужингийн технологийн талаар тавьсан хориггоо хэвээр үлдээж байна.

НҮБ-ын тогтоол гарсан өдрөөс 90 хоногийн дараа буюу 2015 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн ҮАХИБТ хүчин төгөлдөр хэрэгжиж, түүнд оролцогч улсууд хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээ авч эхлэв. ҮАХИБТ хэрэгжиж эхэллээ гэдэг нь Иран цөмийн түлш баяжуулдаг центрифугуудын үйл ажиллагааныхаа хүчин чадлыг бууруулж, Өрнөдийн орнууд тус улсад тавьсан хориггоо цуцална гэсэн үг биш байв.⁵

⁴ Ираны цөмийн хөтөлбөрийн хүрсэн түвшингээс үзэхэд 1 жилийн дотор цөмийн зэвсэгтэй болох боломжтой байв.

⁵ CNN “It’s ‘Adoption Day’ –launch time for Iran nuclear deal” (Oct 19, 2015) edition.cnn.com/2015/10/18/middleeast/iran-nuclear-deal-adoption-day/ (accessed May 9, 2021)

АНУ-ын хууль тогтоомжийн дагуу ҮАХИБТ нь гүйцэтгэх засаглалын байгуулсан гэрээ байв. Олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлахад АНУ-ын Сенатын 2/3-ын санал шаарддаг бол гүйцэтгэх засаглалын байгуулсан гэрээг батлахад Конгрессын зөвшөөрөл шаардлагагүй байдаг. Гэхдээ Конгрессын 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Ираны цөмийн асуудлаарх гэрээг хянах хуулийн дагуу АНУ-ын Конгресс ҮАХИБТ-г 60 өдрийн турш хянаж үзэхээр болсон. Уг хуульд гэрээтэй холбоотой бүх материалыг хүргүүлмэгц Конгресс батлах тогтоолыг 60 өдрийн дотор гаргах ёстой байв. Конгресс батлахгүй гэх тогтоол гаргавал Ерөнхийлөгч Б.Обама хориг тавихаа илэрхийлсэн. Бүгд Найрамдах намынхан Ерөнхийлөгчийн хоригийг хүчингүй болгохын тулд Конгрессын 2 танхимын хоёулангийнх нь гишүүдийн 2/3-ийн саналыг цуглуулах шаардлагатай байсан билээ. Мэрилэнд мужийн сенатор Барбара Микулски Ирантай хийсэн гэрээг дэмжихээ илэрхийлсэн 34 дэх сенатын гишүүн 9 дүгээр сарын 3-ны өдөр болсноор⁶ Ерөнхийлөгч Б.Обама Бүгд Найрамдах намын хууль тогтоогчид энэхүү гэрээг унагаахаас сэргийлж чадсан билээ.

Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөөг 2015 оны 7 дугаар сард эцэслэсний дараа АНУ, Иран нь цөмийн асуудлаарх уулзалтууд болон бусад уулзалтын үеэр хоёр талын асуудлаа ярилцаж байсан. Ерөнхийлөгч Б.Обамагийн хувьд Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөө нь АНУ-Ираны харилцаанд шинэ эрин үеийг эхлүүлнэ гэдэгт найдаж буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ илүү өргөн хүрээнд Ирантай ойртохгүйгээр АНУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах боломжтой хэмээн үзэж байсан юм. Ерөнхийлөгч Б.Обама 2015 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд оролцохдоо Ираны Гадаад хэргийн сайд Зарифтай уулзсан.

Цөмийн гэрээтэй хийгдсэнтэй холбогдуулан хоёр тал харилцаагаа сайжруулахад нэлээд хүчин чармайлт тавьсан. Иран нь Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн өдөр (2016 оны 1 дүгээр сарын 16)-тэй давхцан, тухайн үед Ираны барьцаанд байсан давхар иргэншилтэй хүмүүсийг сулласан. Харин АНУ-ын талаас Шейхийн засаглалын үед нийлүүлэх ёстой байсан цэргийн техник хэрэгсэлийн оронд эргүүлэн төлөх ёстой хэмээн Иран олон жилийн туршид шаардаж байсан 1.7 тэрбум (америк доллараар бус харин евро, швейцарь франкаар илэрхийлэгдсэн)-ыг бэлнээр төлсний 400 сая нь америкийн талын анхлан хүлээн авсан мөнгө бөгөөд 1,3 тэрбум нь арбитраар тохиролцсон хүүнд төлсөн мөнгө юм.

Гэтэл АНУ-д сонгуулийн үр дүнд шинэ засаг захиргаа бүрэлдэв. Д.Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болсноор хоёр улсын харилцаа дахин эдрээтэй байдалд хүрлээ. Түүний засаг захиргаа Ирантай байгуулсан цөмийн гэрээ болох ҮАХИБТ-нөөс гарч буй 2018 оны 5 дугаар сард гарч буйгаа зарласан⁷ нь харилцаанд сөргөөр нөлөөлсөн. Хэдийгээр цөмийн гэрээнд оролцогч бусад талууд ҮАХИБТ “хүчин

⁶ RT “Sealed: Obama Secures Votes to Override Congress on Iran Deal” (Sep 2, 2015) www.rt.com/usa/314113-mikulski-support-iran-deal/ (accessed May 10, 2021)

⁷ The New York Times “Trump Abandons Iran Nuclear Deal He Long Scorned” (May 8, 2018) <https://www.nytimes.com/2018/05/08/world/middleeast/trump-iran-nuclear-deal.html> (accessed May 5, 2021)

төгөлдөр” байгааг онцолсоор⁸ байгаа боловч нөхцөл байдал хэдийн хурцдсан. Д.Трампын засаг захиргааны мэдэгдэлд дурдснаар, “Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөө”-г эцэслэн байгуулснаас хойш Б.Обамагийн засаглалын төгсгөл хүртэл Иран хамгийн багадаа 4 удаа баллистик пуужингийн туршилт хийжээ. Энэ нь НҮБ-ын 2231 тоот тогтоолыг зөрчсөн буюу биелүүлээгүй хэрэг болсон юм. Эдгээр пуужингийн туршилтын улмаас АНУ-ын зүгээс Ираны цөмийн хөтөлбөртэй холбоотой байгууллагуудад хориг тавьсан.

Ерөнхийлөгч Д.Трамп 2015 онд байгуулсан Үйл ажиллагааны хамтарсан иж бүрэн төлөвлөгөөнөөс АНУ-ыг гаргаснаас хойш Иранд “туйлын дарамт шахалт”-ыг үзүүлэх кампанит ажлыг хэд хэдэн алхамтай хийсэн. 2019 оны 5 дугаар сараас хойш АНУ-Ираны зөрчил ихээхэн хурцдаж, зэвсэгт тэмцэлд хүрэхээ шахсан. АНУ-ын талын мэдэгдснээр, Иран болон түүнтэй холбоотой бүлэглэлийнхэн Персийн буланд Арабын улс орнууд онц чухал дэд бүтцүүдэд халдлага, АНУ-ын нисгэгчгүй онгоцыг сөнөөх зэргээр АНУ-ын цэргийн хүч болон ашиг сонирхолд аюул учруулсан. Улмаар 2019 оны 6 дугаар сараас эхлэн Ормузын хоолойн орчимд нөхцөл байдал хурцдаж эхэлсэн. АНУ нь Ормузын хоолой орчим тээвэрлэлт хийж байсан газрын тос тээвэрлэгч онгоцуудыг устгасан хэрэгт Ираныг буруутгаж, нотлох баримтыг дэлгэнэ гэдгээ мэдэгдэж, АНУ-ын 130 сая ам.долларын өртөгтэй нисгэгчгүй онгоцыг буудаж унагасны хариуд Ираны эсрэг хариу цохилт өгөхөөр төлөвлөж байсан боловч эцсийн мөчид шийдвэрээсээ ухарсан. Өөрөөр хэлбэл, хоёр улсын харилцаа үндсэндээ дайны байдалд хүрээд байсан юм.

Саудын Арабын хамгийн том газрын тосны талбайнуудын нэг болох Кураис Йемений босгогчид үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа нисгэгчгүй онгоцны довтолгоонд өртсний улмаас дэлхийн зах зээл дээр боловсруулаагүй газрын тосны үнэ өсч, нефтийн компаниудын хувьцааны ханш мөн өссөн. 2019 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр болсон энэхүү агаарын цуврал довтолгооны улмаас хоногт 7 сая баррель газрын тос боловсруулах хүчин чадалтай Саудын Арабын хамгийн том газрын тос боловсруулах үйлдвэр болох Абкайкийн үйл ажиллагаа доголдож, 5.7 сая баррель газрын тосны үйлдвэрлэлийг зогсоожээ. 2019 оны байдлаар Саудын Араб хоногт 9.85 сая баррель газрын тос үйлдвэрлэсэн нь дэлхийн газрын тосны нийлүүлэлтийн 10 орчим хувь болж байна. 2018 онд тус улсын олборлосон газрын тосны дийлэнх хэсгийг Япон, Хятад, Өмнөд Солонгос, Энэтхэг зэрэг Азийн орнууд импортлож авчээ. АНУ-ын тухайд 21.9 тэрбум ам.долларын газрын тос Саудын Арабаас худалдан авсан. Харин довтолгооны өртсөн газрын тос боловсруулах байгууламж нь дангаараа Саудын Арабын газрын тосны үйлдвэрлэлийн талаас илүү хувь буюу дэлхийн газрын тосны нийлүүлэлтийн 6 хувийг үйлдвэрлэдэг байна.

Саудын Араб нь газрын тосны байгууламжинд халдлага үйлдсэн зэвсгийг Ираных байсан хэмээн үзсэн бол АНУ-ын зүгээс энэ довтолгоонд Иран болон бүс

⁸ CNBC “Iran nuclear deal ‘isn’t dead yet,’ UK says as EU leaders scramble to save it” (July 15, 2019) <https://www.cnbc.com/2019/07/15/eu-leaders-race-to-save-iranian-nuclear-deal-say-it-isnt-dead-yet.html> (accessed May 5, 2021)

нутаг дахь түүний холбоотнуудыг буруутгаж, Ерөнхийлөгч Д.Трамп Вашингтон Ираны үйлдэлд хариу өгөхөд бэлэн байгаа гэдгийг илэрхийлсэн. Халдлагатай холбогдуулан дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ сүүлийн 6 сарын хугацаанд хамгийн их өссөн байна. Олон улсын газрын тосны үнийг хэмжих гол хэрэгсэл болох Брентийн боловсруулаагүй газрын тосны 1 баррель нь 68 ам.доллар байсан бол бараг 12 ам.доллараар нэмэгдэн 71.95 ам.долларт хүрсэн байна.⁹

Улмаар АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуулийн үр дүнд Ерөнхийлөгч Б.Обамагийн засаг захиргааны үед Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Жо Байден Цагаан Ордоны тэргүүн болж, Ерөнхийлөгч Ж.Байдены АНУ-ын Ойрхи Дорнодын бүс нутгийн бодлогыг “Обама 2.0” бодлого хэмээн судлаачид тодорхойлж байв. Мөн Ерөнхийлөгч Ж.Байдены үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын багт өмнө нь Ирантай цөмийн гэрээ байгуулахад голлох үүрэгтэй оролцсон хүмүүс багтсан. Тухайлбал, Ирантай цөмийн гэрээ байгуулахад голлох үүрэгтэй оролцсон Жэйк Сулливаныг Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөөр томилогдсон бол Төрийн нарийн бичгийн даргын хувиар АНУ-ыг төлөөлөн гэрээ хэлэлцээ хийсэн Жон Керри АНУ-ын Ерөнхийлөгчийн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн Тусгай элчээр томилогдоод байна. Энэ нь Ирантай байгуулсан цөмийн гэрээ болох ҮАХИБТ-нд АНУ эргэн нэгдэнэ гэсэн хүлээлтийг бий болгосон.

Хүлээлт бодитой байж, АНУ-ын болон Ираны дипломатууд цөмийн гэрээ дахин байгуулахын тулд зуучлагч орнуудаар дамжуулан Австрийн Вена хотод яриа хэлэлцээ 2021 оны 4 дүгээр сараас хийж эхэлсэн. Яриа хэлэлцээ амжилттай болсон тохиолдолд, 2015 онд байгуулсан ҮАХИБТ ахин хүчин төгөлдөр хэрэгжих юм. Ингэснээр, Иран цөмийн хөтөлбөрөө хязгаарласны хариуд АНУ нь Д.Трампын засаг захиргааны үед Иранд тавьсан хоригуудыг цуцлах боломжтой болно.

Вашингтон, Тегеран хоёр тохиролцоонд хүрэхэд нэлээд хугацаа шаардлагатай. Юуны түрүүнд, хоёр улсын харилцааг муудахад хүргэж болзошгүй олон асуудал бий. Үүнээс болоод яриа хэлэлцээ зогсонги байдалд орж болох юм. Тухайлбал, Олон улсын цөмийн эрчим хүчний байгууллагын 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр гаргасан нууц тайланд дурдснаар Иран уран металл боловсруулах үйл ажиллагаа сэргээсэн бөгөөд энэ явдал нь яриа хэлэлцээг хойш нь татсан алхам боллоо гэдгийг АНУ-ын тал анхааруулаад байна. Нөгөө талаар, Ираны Ерөнхийлөгчийн сонгууль 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр болж, хатуу консерватив үзэлтэй Эбрахим Райси тус улсын ерөнхийлөгч болоод байна. Хэдийгээр Э.Райси АНУ-тай байгуулсан цөмийн гэрээний гэрээг эхэндээ эсэргүүцэж байсан боловч энэ удаад дэмжих бодлого баримтлах төлөвтэй байна. Аядуу үзэлтэй өмнөх Ерөнхийлөгч Х.Руханиг бодвол АНУ-тай гэрээ байгуулахад Ираны үндэсний ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэхээ мэдэгдээд байгаа билээ.

⁹ The Guardian “Saudi Arabia oil attack: Trump hints at action as US points finger at Iran” (Sep 16, 2019) <https://www.theguardian.com/world/2019/sep/16/trump-says-us-locked-and-loaded-after-saudi-arabia-oil-attack-as-crude-prices-soar-iran-aramco> (accessed May 2, 2021)

Хоёр. Ираны цөмийн гэрээ ба газрын тосны үнэд үзүүлэх нөлөө

Иран улс нь 156 сая баррель нөөцөөрөө дэлхийд 4 дүгээрт орж, дэлхийн газрын тосны нөөцийн 9.5 хувийг эзэмшдэг¹⁰ бол ОПЕК (Газрын тос экспортлогч орнуудын байгууллага)-ийн орнуудын дотор газрын тосны үйлдвэрлэлээрээ 7 дугаарт ордог.¹¹ Тус улс өдөрт 2.5 сая баррель газрын тос үйлдвэрлэдэг нь дэлхийн нийт эрэлтийн орчим 3 хувь болох юм.

Ираны тухайд АНУ-тай хийж буй яриа хэлэлцээ амжилтанд хүрнэ гэх хүлээлт байгаа учраас хориг цуцлагдсан тохиолдолд газрын тосны олборлолт, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр бэлдэж байна. Австрийн Вена хотод болж байгаа АНУ болон бусад улстай хийж буй яриа хэлэлцээнд Ираныг төлөөлөн гол яриа хэлэлцээг хийж буй Ираны Гадаад хэргийн дэд сайд Аббас Арачи 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр мэдэгдснээр хэлэлцээнд нааштай дэвшил гарч байна.¹² АНУ-ын хориг цуцлагдсан тохиолдолд, хамгийн өөдрөг хувилбараар авч үзвэл, гурван сар хүрэхгүй хугацаанд Иран хориг тавихаас өмнөх хэмжээ буюу өдөрт 4 сая баррельд хүргэж газрын тосны үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломжтой хэмээн Ойрхи Дорнодын бүс нутаг, түүний дотор Иранд ажиллаж байсан Фактс Глобал Энержи эрчим хүчний зөвлөх үйлчилгээний компанийн Ойрхи Дорнод хариуцсан захирал Иман Насери үзэж байгаа юм.¹³

Шинжээчдийн зарим нь Ираны газрын тосны үйлдвэрлэл үүнээс илүү удаан хугацаанд сэргэнэ хэмээн үзэж байна. Хориг цуцлагдснаас хойш өдөрт 3.8 сая баррель хүргэж олборлолтыг нэмэгдүүлэхийн тулд 12-15 сарын хугацаа шаардагдана хэмээн Тегераны Худалдааны танхимын Эрчим хүчний комиссын дарга Реза Падидаар тооцож байна. Түүний хэлснээр, газрын тосны зарим талбайн хүчин чадлыг сэргээхэд нэлээд хугацаа шаардлагатай. Тухайлбал, хаагдсан цооногийн шахуургыг авч, засвар үйлчилгээ хийхэд 1 худагт гэхэд 1 сарын хугацаа шаардагдахаар байна.¹⁴

Ираны газрын тосны үйлдвэрлэл сэргэснээр ОПЕК болон түүний холбоотнуудад хүндрэл учрах төлөвтэй байна. Саудын Араб болон ОХУ-ын тэргүүлдэг 23 улсын эвсэл коронавирусын цар тахлын улмаас эрэлт багассантай холбогдуулан үйлдвэрлэлээ бууруулсан. Харин вакцинжуулалт эхэлснээр дэлхийн эдийн засаг сэргэх төлөв ажиглагдсан тул нийлүүлэлтээ аажмаар нэмэгдүүлэх бодлого баримталж байна. ОПЕК болон түүний холбоотнууд нийлүүлэлтээ нэмэгдүүлэхэд болгоомжтой хандснаар Брентийн төрлийн газрын тосны үнэ энэ онд 33 хувиар

¹⁰ NS Energy Staff Writer “Top ten countries with the world’s largest oil reserves in 2019”(Nov 4, 2020) <https://www.nsenergybusiness.com/features/newstop-ten-countries-with-worlds-largest-oil-reserves-5793487/>

¹¹ Zhukov, S.V., Reznikova, O.B. Iran in the Global Oil Market. Her. Russ. Acad. Sci. 90, 708–717 (2020). <https://doi.org/10.1134/S1019331620060106>

¹² Arsalan Shahla “Iran preps new oil export terminal beyond Strait of Hormuz” (May 19, 2021) <https://www.worldoil.com/news/2021/5/19/iran-preps-new-oil-export-terminal-beyond-strait-of-hormuz>

¹³ Anthony Di Paola, Arsalan Shahla, and Grant Smith, Bloomberg “Iran Gears Up for Return to Oil Market as U.S. Talks Advance” (May 16, 2021) <https://www.bloomberg.com/news/articles/2021-05-15/iran-gears-up-for-return-to-oil-market-as-u-s-talks-advance> (accessed May 17, 2021)

¹⁴ Мөн тэнд

өсч, баррель нь бараг 69 ам.долларт хүрээд байгаа билээ. Саудын Арабын Эрчим хүчний сайд, хунтайж Абдулазиз бин Салман Иран улс өмнөх шигээ үйлдвэрлэлээ нэмэгдүүлвэл ОПЕК+ эвсэл Ираны үйлдвэрлэл сэргэхийг хүлээн авах боломжтой хэмээн мэдэгдсэн. Бусад улсууд тэр дундаа ОХУ, Арабын Нэгдсэн Эмират энэ асуудалд таатай хандах эсэх нь тодорхойгүй байна.

Иран улсын стратегийн хамгийн том давуу тал нь дэлхийн газрын тосны тээвэрлэлтэд нэн чухал ач холбогдолтой Ормузын хоолойг Иран хянадаг явдал юм. Их гүрнүүдийн өрсөлдөөний талбар болсон Ормузын хоолой нь Ираны өмнөд хэсэг, Оманы умард хэсэгт байрладаг бөгөөд Персийн булангаас Арабын тэнгис, Энэтхэгийн далай руу хүрэх цорын ганц гарц ба дэлхийн эрчим хүчний нийлүүлэлтэд чухал үүрэгтэй (Зураг 1-ийг үзнэ үү). Энэ хоолойгоор газрын тосны баялаг ихтэй Иран, Ирак, Кувейт, Бахрейн, Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират газрын тос, байгалийн хий дэлхийн бусад оронд экспортолж байна.

Зураг 1. Ормузын хоолой



Тоо баримт дурдвал, дэлхийн газрын тосны экспортын 40-46 хувь нь энэ хоолойгоор дамждаг бөгөөд цаашид тээврийн хэмжээ өсөх төлөвтэй байна. Энэ замаар тээвэрлэх газрын тосны хэмжээг жилд дунджаар 2 хувиар тогтмол өснө гэж тооцоод, 2030 он гэхэд дэлхийн газрын тосны нийлүүлэлтийн 2/3 нь Персийн булангаар дамжина хэмээн Олон улсын эрчим хүчний агентлаг таамаглаж байна. Ормузын хоолойгоор 1 өдөрт 17 сая баррель газрын тос тээвэрлэдэг нь далайгаар дамжин хийгддэг дэлхийн худалдааны 30 хувийг болно. Мөн Ормузын хоолойгоор жилд дунджаар 33 тэрбум куб метр байгалийн хий тээвэрлэдэг нь жилд дунджаар

14 тэрбум куб метр байгалийн хий тээвэрлэдэг Гибралтарын хоолойгоос 2 дахин их байгаа юм.

АНУ-ын эрчим хүчний мэдээллийн агентлагийн гаргасан мэдээгээр Азийн зах зээлд хүрдэг түүхий нефтийн 85 хувь нь энэ хоолойгоор дамждаг байна¹⁵. Япон, Энэтхэг, БНСУ, Хятад бол Ормузын хоолойгоор дамжуулан газрын тос хамгийн ихээр авдаг орнуудад тооцогддог. Бритиш Петролиумын гаргасан статистикаар Катар улс 2016 онд 3.7 их наяд куб фийт шингэрүүлсэн байгалийн хийг Ормузын хоолойгоор дамжуулан экспортолжээ¹⁶. Энэ нь дэлхийн нийт шингэрүүлсэн байгалийн хийн 30 гаруй хувь болно. Кувейт энэ хоолойгоор дамжин баруун урагш явсан хоолойгоос шингэрүүлсэн байгалийн хий импортолдог. Тиймээс Ормузын хоолойн орчим зэвсэгт мөргөлдөөн, дайн бүхий байдал үүсвэл дэлхийн газрын тосны нийлүүлэлт саатах, үнэ өсөхөд шууд нөлөөлнө.

АНУ болон бусад улстай үүссэн асуудлаа шийдвэрлэхэд Иран нь Ормузын хоолойг “хөзөр” болгон ашигладаг. Тодруулбал, Иран тодорхой нэг асуудлыг өөрт ашигтайгаар шийдвэрлээгүй тохиолдолд энэ хоолойг хаана хэмээн сүрдүүлдэг. Ираны цөмийн хөтөлбөр 2012 онд хэрэгжүүлсэн учраас АНУ, Европын холбооны хориг арга хэмжээний авч, хариуд нь тус хоолойг хаана хэмээн заналхийлж байв. Ираны тэнгисийн цэргийн командлагч Ормузын хоолойг хаах нь “амархан” хэмээн мэдэгдэж байлаа. Мөн Ираны эсрэг илүү хатуу хориг арга хэмжээ авах юм бол “дусал” ч газрын тос нэвтрүүлэхгүй хэмээн Ираны Дэд ерөнхийлөгч анхааруулсан удаатай.¹⁷ Хэдийгээр хориг арга хэмжээ бодитой хэрэгжсэн боловч Иран нь тус хоолойг газрын тос чөлөөтэй нэвтрүүлсэн хэвээр байсан юм. 2018 онд АНУ-аас Ираны эсрэг хориг тавихад Иран үүнийг эсэргүүцэн, Ормузын хоолойг хаана хэмээн сүрдүүлж байв. Гэвч мөн л тус хоолойн үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тавиагүй юм.

Түүнчлэн энэ хоолойгоор дамжин тээвэр хийж байсан худалдааны хөлөг онгоцуудыг сүйрүүлж байсан тохиолдлууд ч бий. Жишээ дурдахад, 1980-аад онд Иран, Иракийн хооронд болсон дайны тулалдааны гол талбар нь Ормузын хоолой болсон. “Танкируудын дайн” гэж нэрлэгдсэн уг дайнд талуудын аль аль нь нөгөөгийнхөө эрчим хүчний экспортын хөлөг онгоцуудыг живүүлэхийг оролдож байв.¹⁸ Дайнд өртөж хохирохоос зайлсхийхийн тулд Кувейт газрын тосны хөлөг онгоцууд аль улсынх гэдгээ нууж, АНУ-ын далбаан дор хөвж байлаа. Энэ дайн дууссанаас хойш газрын тосны тээвэрлэлт хэвийн болсон ч Ормузын хоолойд тээвэр хийдэг хөлөг онгоцуудын даатгал 400 орчим хувиар нэмэгджээ.¹⁹

¹⁵ Lloyd's List Intelligence, *Analysis of Petroleum Exports (APEX) database*

¹⁶ BP, *Statistical Review of World Energy 2014* (June 2014).

¹⁷ Stratfor Worldview “Why Iran Is Threatening to Close the Strait of Hormuz” (July 6, 2018) https://www.realcleardefense.com/articles/2018/07/06/why_iran_is_threatening_to_close_the_strait_of_hormuz_113583.html

¹⁸ “Iran-Iraq War and Navigation in the Gulf” *International Legal Materials* 26, no. 5 (1987): 1422-487. Accessed May 21, 2021. <http://www.jstor.org/stable/20693160>.

¹⁹ The New York Times “Insuring ‘War Risks’ at Lloyd’s” (Jan 16, 1991) <https://www.nytimes.com/1991/01/16/business/insuring-war-risks-at-lloyd-s.html>

Ямартаа ч Ормузын хоолой хаасан тохиолдолд дэлхийн газрын тосны экспортын 40-46 хувь нь тасалдах аюулд орно. Ийм асуудалд үүссэн тохиолдолд Венесуэл, ОХУ зэрэг Ормузын хоолойгоос хамааралгүй улсууд газрын тосны үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломжтой боловч энэ нь тасалдсан нийлүүлэлтийг бүрэн хангахад хаана нь ч хүрэхгүй юм. Тиймээс энэ хоолойн тасралтгүй үйл ажиллагааг хангах нь дэлхийн эдийн засагт чухал нөлөөтэй гэдэг нь маргаангүй юм.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байдены засаг захиргаа Ирантай харилцах харилцаанд нааштай дэвшил авчирч магадгүйгээс үзэхэд Ормузын хоолойн орчимд нөхцөл байдал тогтворжиж, цаашид дэлхийн газрын тосны зах зээлд сөрөг үзүүлэх гэнэтийн, тааварлашгүй үйл явдал гарах магадлал нь буурах төлөвтэй байна. Венад болж буй яриа хэлэлцээ нааштай явагдаж байгаа учраас Ираны тал Ормузын хоолойг дайран өнгөрөх Жаск хэмээх шинэ боомтоос газрын тос экспортлоход бэлдэж байна хэмээн төрийн өмчит Ираны Үндэсний газрын тос компанийн мэдэгдэлд дурджээ. Жаск боомтыг Ираны баруун өмнөд хэсэгт байрлах Горех боомтын 1,000 км газрын тос дамжуулах хоолойгоор газрын тос шахаж эхэлсэн байна. Ираны Ерөнхийлөгч Х.Роухани дамжуулах хоолойг албан ёсоор нээх бөгөөд нээх өдрийг тодорхой зарлаагүй байна.²⁰

Гурав. Монгол Улсад үзүүлэх нөлөө

Монгол Улсын тухайд авч үзвэл, манай эдийн засагт газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл ихээхэн нөлөөтэй. Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх хандлага 2013 оноос өмнө манайд түгээмэл ажиглагдаж байсан. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд шатахууны үнийн өсөлт махнаас бусад өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийн 30 хувийг дангаараа бүрдүүлж байсан тохиолдол ч бий. Шатахууны бүтээгдэхүүнийг орц болгон ашигладаг салбаруудын бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өсөлтийг оруулж тооцвол энэ дүн бүр ч өндөр байх болно.²¹


Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт барьж, 2023 онд ашиглалтанд орохоор төлөвлөгөөтэй байгаа 1.5 сая тонн хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэрийг эс тооцвол манай улс түлш шатахууны тухайд импортоос 100 шууд хамааралтай. Импортлогч улсуудыг авч үзвэл, Монгол Улс газрын тосны хэрэглээнийхээ дийлэнх хэсгийг буюу 93 гаруй хувийг ОХУ-аас импортлон авч байгаа бол импортын 4.6 хувийг БНСУ, 2 хувийг БНХАУ, үлдсэнийг бусад улсаас импортлож байна (Зураг 2-ыг үзнэ үү). Энэ утгаараа, Монгол Улс нь нефтийн бүтээгдэхүүний хувьд ОХУ-аас бүрэн хараат гэж дүгнэж болохоор байна.²²

²⁰ Arsalan Shahla “Iran preps new oil export terminal beyond Strait of Hormuz” (May 19, 2021) <https://www.worldoil.com/news/2021/5/19/iran-preps-new-oil-export-terminal-beyond-strait-of-hormuz>

²¹ Б.Мөнхзул, (Монголбанкны ОНБМТ-ийн эдийн засагч) “Газрын тосны үнийн хэлбэлзлийн 40 жилийн түүх: яагаад нефтийн үнэ одоо ч биднийг гайхшруулж болох вэ?” 2017/01/30 <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1385&tid=2>

²² Ашигт малтмал, газрын тосны газар “Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, импорт” <https://mrgpm.gov.mn/article/94/>

Зураг 2. 2016 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүн



Хэдийгээр манай газрын тосны импорт ОХУ-ын зах зээлийн байдлаас бүрэн хамааралтай мэт боловч нөгөө талаар дэлхийн зах зээлд гол үүрэгтэй Ойрхи Дорнодын нөхцөл байдал манай улсад шууд бусаар нөлөөлж байна. Ойрхи Дорнод тогтворгүй байдал хурцадсан тохиолдолд, дэлхийн зах зээл дээр газрын тосны нийлүүлэлт тасалдах, үүнээс шалтгаалан үнэ өсөх эрсдэлтэй. Энэ нь ОХУ-ыг үнэ өсгөхөөс өөр аргагүй байдалд хүргэж, эргээд бидний хэрэглэж буй бензин шатахуун үнэ өсөхөд нөлөөлнө.

Эсрэгээрээ, АНУ-Ираны харилцаа нааштайгаар эргэж, цөмийн гэрээ дахин байгуулсан тохиолдолд дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурах боломжтой. Иран улс цөмийн хөтөлбөрөө зогсоож, АНУ тус улсад хоригоо цуцалж, Ираны газрын тос дэлхийн зах зээлд чөлөөтэй нийлүүлэгдэх боломжтой болох эсэх нь цөмийн гэрээ байгуулж чадах эсэхээс шууд хамаарна. Гэрээ хэлэлцээ амжилттай хийгдсэн тохиолдолд газрын тос буурах магадлалтай учраас манай улс энэ боломжийг ашиглан газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд анхаарах боломжтой.

Гэвч газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх арга нь үнийн хэлбэлзэл, зах зээлийн тодорхой бус байдлаас үүсэх эрсдэлийг бууруулах, гэнэтийн шок үүссэн үед бүрдүүлсэн нөөцөө ашиглахад чиглэдэг боловч газрын тосны үнийн хэлбэлзлийг багасгах, хэлбэлзлээс үүсэх эдийн засаг дахь сөрөг нөлөөг дорвитой бууруулах бүрэн шийдэл болж чаддаггүй. Ийм учраас газрын зах зээл дээр үүсэж болзошгүй шокын сөрөг нөлөөг аль болохоор бага байлгах тулд манай улс нефтийн үнийг урьдчилан таамаглах, болзошгүй эрсдэлд бэлтгэх, фьючерс гэх мэт үүсмэл хэрэгсэл ашиглан ирээдүйн үнийн тодорхой бус байдлыг бууруулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

АНУ нь Ойрхи Дорнодын бүс нутагт аль улсыг дэмжихээс шалтгаалан бүс нутгийн хүчний тэнцвэр өөрчлөгдөж байна. Вашингтон 1979 оны хувьсгалаас өмнө Ираныг дэмжиж байсан бол өнөөдөр Саудын Араб, Израйль нь Вашингтоны бүс нутаг дахь гол холбоотон болж байна. Б.Обамагийн засаг захиргаа Ирантай цөмийн гэрээ хийсэн явдлыг хамгийн их эсэргүүцсэн улсууд нь мэдээжийн хэрэг Саудын Араб, Израйль байв. Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа өмнөх ерөнхийлөгчийн Ойрхи Дорнодод явуулж байсан бодлогыг өөрчлөн, “уламжлалт чиглэл” буюу Саудын Араб, Израйлийг дэмжихийн зэрэгцээ Ираныг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлсэн.

Д.Трампын засаг захиргаа АНУ-ыг олон улсын хэмжээнд байгуулсан цөмийн гэрээнээс гаргахаар шийдвэрлэсэн явдал нь бүс нутагт тогтворгүй байдлыг дэвэргэсэн. Үүнээс болоод АНУ, Иран дайны байдалд шилжихэд тун ойртсон үйл явдал 2019 оны 8 дугаар сард өрнөсөн билээ. АНУ болон Ираны албан тушаалтнуудын аль аль нь үүссэн асуудлыг цааш нь даамжруулж, зэвсэгт мөргөлдөөнд хүрэхийг хүсэхгүй гэдгээ илэрхийлсэн. Гэсэн хэдий ч аль нэг нь халдлага үйлдсэн тохиолдолд нөгөө тал нь хүч хэрэглэхэд бэлэн гэдгээ мөн зарлаад байв. Өөрөөр хэлбэл, хоёр улс дайнд татагдан ороход тун ойртоод байсан юм.

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуулийн үр дүнд шинэ засаг захиргаа ажилдаа орсноор Вашингтоны Ойрхи Дорнод, түүний дотор Ираны талаар явуулах бодлого огцом өөрчлөлт гарах төлөвтэй болсон. Тодруулбал, Ерөнхийлөгч Ж.Байдены аюулгүй байдал, гадаад бодлогын багт Ирантай өмнө нь цөмийн гэрээ байгуулахад гар бие оролцож байсан төрийн зүтгэлтнүүд багтсан явдал АНУ нь Ирантай дахин цөмийн гэрээ байгуулж, өмнөх Ерөнхийлөгч Д.Трампын Ираны талаар явуулж байсан “хатуу” бодлого зөөлрөх магадлалтай хэмээн дүгнэхэд хүргэсэн. Энэхүү таамаг оргүй, хоосон биш болох нь Ж.Байдены засаг захиргаа Ирантай цөмийн гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ өрнүүлснээр батлагдаж байна. Хэрэв энэ яриа хэлэлцээ амжилттай өндөрлөх юм бол дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурах боломжтой.

Цөмийн гэрээ байгуулах яриа хэлэлцээ амжилттай өндөрлөсөн ч гэсэн Иран улс газрын тосоо дэлхийн зах зээлд тэр дор нь нийлүүлэх боломжгүй, зарим засвар, шинэчлэлийн ажил хийх шаардлагатай. Тегераны зүгээс гэрээ хэлэлцээний хэтийн төлөвийг нааштай үнэлж байгаа учраас хориг цуцлагдсны дараа дэлхийн зах зээлд газрын тосоо нийлүүлэх бэлтгэл ажлаа хангаж байна. Тухайлбал, дэлхийн газрын тосны тээврийн гол артерын судас болох Ормузын хоолойн орчимд шинэ боомт барьж, ашиглалтанд оруулахад хэдийнэ бэлэн болоод байна.

АНУ нь Ирантай харилцаагаа сайжруулах нь зөвхөн дэлхийн зах зээл дээрх газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлээд зогсохгүй дэлхийн газрын тосны тээвэрт онц чухал үүрэгтэй Ормузын хоолойн тасралтгүй ажиллагааг хангах, Иран тус хоолойг улс төрийн зорилгод ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Өөрөөр хэлбэл, АНУ-Ираны харилцаа ямар байхаас шалтгаалан Ормузын хоолойн аюулгүй байдал хангагдаж, улс орнуудын газрын тос тээвэрлэсэн хөлөг онгоцууд чөлөөтэй зорчих бололцоотой болно.

Хэдийгээр Монгол Улс нь газрын тосны хувьд ОХУ-аас бүрэн хараат боловч дэлхийн зах зээлд гол үүрэгтэй Ойрхи Дорнодын нөхцөл байдал манай улсад шууд бусаар нөлөөлж байна. АНУ-Ираны харилцаа нааштайгаар эргэж, цөмийн гэрээ дахин байгуулсан тохиолдолд дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурах төлөвтэй юм. Иймд газрын зах зээл дээр үүсэж болзошгүй шокын сөрөг нөлөөг аль болохоор бага байлгах зорилгоор манай улс нефтийн үнийг урьдчилан таамаглах, болзошгүй эрсдэлд бэлтгэх, фьючерс гэх мэт үүсмэл хэрэгсэл ашиглан ирээдүйн үнийн тодорхой бус байдлыг бууруулах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Ашигт малтмал, газрын тосны газар “Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, импорт” <https://mgram.gov.mn/article/94/>

Б.Мөнхзул, (Монголбанкны ОНБМТ-ийн эдийн засагч) “Газрын тосны үнийн хэлбэлзлийн 40 жилийн түүх: яагаад нефтийн үнэ одоо ч биднийг гайхшруулж болох вэ?” 2017/01/30 <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1385&tid=2>

Anthony Di Paola, Arsalan Shahla, and Grant Smith, Bloomberg “Iran Gears Up for Return to Oil Market as U.S. Talks Advance” (May 16, 2021) <https://www.bloomberg.com/news/articles/2021-05-15/iran-gears-up-for-return-to-oil-market-as-u-s-talks-advance> (accessed May 17, 2021)

Arsalan Shahla “Iran preps new oil export terminal beyond Strait of Hormuz” (May 19, 2021) <https://www.worldoil.com/news/2021/5/19/iran-preps-new-oil-export-terminal-beyond-strait-of-hormuz>

BP, *Statistical Review of World Energy 2014* (June 2014).

CNBC “Iran nuclear deal ‘isn’t dead yet,’ UK says as EU leaders scramble to save it” (July 15, 2019) <https://www.cnbc.com/2019/07/15/eu-leaders-race-to-save-iranian-nuclear-deal-say-it-isnt-dead-yet.html> (accessed May 5, 2021)

CNN “It’s ‘Adoption Day’ –launch time for Iran nuclear deal” (Oct 19, 2015) edition.cnn.com/2015/10/18/middleeast/iran-

nuclear-deal-adoption-day/ (accessed May 9, 2021)

“Iran-Iraq War and Navigation in the Gulf” *International Legal Materials* 26, no. 5 (1987): 1422-487. Accessed May 21, 2021. <http://www.jstor.org/stable/20693160>.

Lloyd’s List Intelligence, *Analysis of Petroleum Exports (APEX) database*

NS Energy Staff Writer “Top ten countries with the world’s largest oil reserves in 2019”(Nov 4, 2020) <https://www.nsenergybusiness.com/features/newstop-ten-countries-with-worlds-largest-oil-reserves-5793487/>

RT “Sealed: Obama Secures Votes to Override Congress on Iran Deal” (Sep 2, 2015) www.rt.com/usa/314113-mikulski-support-iran-deal/ (accessed May 10, 2021)

Stratfor Worldview “Why Iran Is Threatening to Close the Strait of Hormuz” (July 6, 2018) https://www.realcleardefense.com/articles/2018/07/06/why_iran_is_threatening_to_close_the_strait_of_hormuz_113583.html

The New York Times “Insuring ‘War Risks’ at Lloyd’s” (Jan 16, 1991) <https://www.nytimes.com/1991/01/16/business/insuring-war-risks-at-lloyd-s.html>

The New York Times “Text: Obama’s Speech in Cairo” (June 4, 2009) <https://www.nytimes.com/2009/06/04/us/politics/04obama.text.html> (accessed May 1, 2021)

The New York Times “Trump Abandons Iran Nuclear Deal He Long Scorned” (May 8, 2018) <https://www.nytimes.com/2018/05/08/world/middleeast/trump-iran-nuclear-deal.html> (accessed May 5, 2021)

The Guardian “Saudi Arabia oil attack: Trump hints at action as US points finger at Iran” (Sep 16, 2019) <https://www.theguardian.com/world/2019/sep/16/trump-says-us-locked-and-loaded-after-saudi-arabia-oil-attack-as-crude-prices-soar-iran-aramco> (accessed May 2, 2021)

Zhukov, S.V., Reznikova, O.B. Iran in the Global Oil Market. *Her. Russ. Acad. Sci.* 90, 708–717 (2020). <https://doi.org/10.1134/S1019331620060106>